

МОНГОЛ ХЭЛНИЙ ОЙРОЛЦОО УТГЫН  
ТОГТОЛЦООГ СУДЛАХУЙ

Ж.Бат-Ирээдүй<sup>1</sup>

Ерөнхий зүйл. Аливаа хэлний ойролцоо утга гэдэг бол нэг талаас хэлний хамгийн чухал судлагдахуун, нөгөө талаас бас хамгийн хэрэгцээтэй хэрэглэгдэхүүн байдаг. Монгол хэлний хувьд хэлний онолын талаас судалж байсан, хэрэглээний талаас ойролцоо утгатай үг хэллэгийн сан бүрдүүлж байсан их эртнийх биш ч хуучин уламжлал бий. Монгол хэлний ойролцоо утгын судалгаа 1990-ээд оны дунд хүртэл дайвар шинжтэй байсан бол сүүлийн жилүүдэд судлаачид энэ тал руу анхааран нэг сэдэвт зохиолын хэмжээнд хүртэл дорвитой судалгаа хийсээр хэд хэдэн нэг сэдэв зохиол туурвисан байна.

Монгол хэлний ойролцоо утгын судалгааг ажиглавал дотоодын болон гадаадын монголч эрдэмтэн олон хүн судлан шинжилсний дотор, академич Ш.Лувсанвандан, М.Гаадамба, Т.Пагва, С.Лувсанвандан, Б.Сумьяабаатар, Ц.Өлзийхутаг, Ж.Төмөрцэрэн, Н.Б.Дугаров, П.Бямбасан, Д.Отгонсүрэн, Б.Пүрэв-Очир, М.Базаррагчаа, Ц.Сүхбаатар, Ц.Өнөрбаян, Д.Бадамдорж, Ж.Бат-Ирээдүй, Ж.Баянсан, Б.Мөнгөнцэцэг, Б.Идэрбаяр тэргүүтэн хэлбичиг, хэлшинжлэлийн талаас, Ц.Хасбаатар, С.Дулам, Д.Галбаатар, Г.Галбаяр тэргүүтэн утга зохиол шинжлэлийн талаас тус тус туурвиж бичсэн байна.

Гадаад дотоодын эрдэмтэдийн судалгааны бүтээл ном сурах бичиг гарын авлага тэргүүтнийг нийтэд нь ажиглавал нэр томъёоны хувьд нэгдэн тогтоогүй, ойролцоо утгатай үг хэллэгийн судалгаа бусдаасаа түлхүү, бусад нэгжийн ойролцоо утгын судалгаа хоцорсон байдалтай. Ойролцоо үг, хэллэгийн утгын бүрэлдэхүүн тооны хувьд янз бүр, утгын ангилалыг бүтцийн ангилалтай хольж хутгасан байх зэрэг олон учир дутагдал ажиглагдаж байна.

Аль ч хэлийг задлаг байдлаар судлана гэвэл шүтэн барилдаж бүтсэн бүх юм үзэгдэл тэдгээрийг төлөөлсөн хэлний дохио бүхнийг дотоод орчин буюу хэсгүүдийг нь гэж гадаад орчин буюу гаднах хэсгүүдийг нь авч гадагш харьцуулбал бодитой, тусгай хэсэг зүйл болж, гадаад орчин буюу хэсгүүдийг нь дотогш нь харьцуулбал хийсвэр ерөнхий бүхэл зүйл болно гэсэн үг. Өөрөөр хэлбэл хэлний бүх л нэгжүүд бүтээвэр, үг, холбоо үг, өгүүлбэр ч бодитой бас хийсвэр, тусгай бас ерөнхий, хэсэг ба бүхэл зүйл болно гэж хэлж болно.

Үгийн утга бол үг, нэрлэсэн юм, илрэх ухагдахуун гурвын диалектик нэгдэл болж байдаг. Ингэж үг, утгын хоорондын бүтцийн харьцаанаас үндэслэн үгийн сангийн хамгийн чухал гурван хэв шинж буюу харьцаа болох ойролцоо, эсрэг, ижил гэсэн гурван ойлголт гардаг бөгөөд ойролцоо утга нь аль ч хэлний үгийн сангийн хамгийн чухал хэсэг байдаг билээ.

Хэл шинжлэлийн онолд хүн төрөлхтөний хэл бол ерөнхийдөө үгийн хэл гэж тодорхойлсон нийтлэг үзэл баримтлал байдаг учраас хэлний үндсэн нэгжийг үг гэж үздэг. Үнэхээр аль хэлэнд үг онцгой байр суурьтай байдаг. Үг нь хэлний харилцаанд гүйцэтгэж байгаа үүрэг шинж чанараараа хэлний аль ч нэгжээс давуу чанартай бөгөөд үгийн сан, хэлзүйн утгыг

1. Монгол Улсын Их Сургууль

нээж өгүүлбэрийн үндсэн хэрэглэгдэхүүн болж тэр ч байтугай харилцааны тодорхой нөхцөлд өгүүлбэрийн үүрэг гүйцэтгэж мэдээллийг дамжуулж чаддаг “ид шид”-тэй нэгж билээ. Гэхдээ энэ өгүүлэлд бид гагц ойролцоо утгат үг, хэллэгийн тухай биш хэлний нийт нэгжийн тухай ойролцоо утгын тогтолцооны тухай авч үзэх билээ.

Энэ ойролцоо утга гэдэг ойлголт зөвхөн үгийн сангийн төвшинд биш хэлний их бага нэгжийн бүх төвшинд яригдах өргөн асуудал юм. Үгийн сангийн төвшинд үг, хэллэгийн ойролцоо утгын тухай яригддаг байсан энэ ойлголт одоо хэлний бага нэгжээс их нэгж хүртэл яригдах хэмжээнд судлагдаж байна гэсэн үг билээ. Монгол хэл бол ойролцоо утгын тогтолцоотой хэл бөгөөд монгол хэлний бүх төвшинд энэ ойлголтыг ярьж болно.

Профессор Б.Пүрэв-Очир, “Монгол хэлний үгийн язгуур ба дагаварт ойролцоо утга байдгаас үгийн сангийн салангид үгс-нэрлэлтүүд ойролцоо утгатай болдог байна. Бас хэлзүйн утгатай морфемууд ойролцоо утгатай байж болдог учраас бүтэц өгүүлбэрийн дотор харьцаанд орсон буюу эсвэл харьцаанд ороход бэлтгэгдсэн хэлзүйжсэн үг буюу хэлбэржсэн үгэнд ойролцоо утга гардаг байна. Нэгэнт хэлбэржсэн үг (өгүүлбэрзүйн үг) ойролцоо утгатай байж болдогос үүдэж, нийлмэл үг, хоршоо үг, хэвшмэл хэлц, тэрчлэн чөлөөт бус холбоо үгс ч өөр хоорондоо ойролцоо утгатай байж болох зүй тогтол гарна. Эдгээр нь цаашлаад өгүүлбэрүүдийн хооронд, улмаар цогцолборын ба “эх”-үүдийн хооронд ойролцоо утга үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг байна.”<sup>2</sup> гэж монгол хэлний ойролцоо утгын тогтолцооны учир холбогдолыг нэгтгэн дүгнэжээ.

Профессор П.Бямбасан, “Синоним гэгч нь утга ойролцоо янз бүрийн аймгийн үг байдаг бөгөөд синоним гэдэг нэр нь дэлхий нийтэд ихэд дэлгэрсэн учир энэ нарийг нь хэрэглэвэл ашигтай мэт санагдана”<sup>3</sup> гэж үзэж байсан бол ер нь synonym гэдэг нэр томъёог юуны өмнө ойролцоо нэр гэж орчуулж, толилож ирсэн боловч ойролцоо утга илэрхийлдэг хэлний аливаа арга хэрэглүүр болох ойролцоо утгатай язгуур, үндэс, дагавар, нөхцөл, үг, хэллэг, өгүүлбэр, эх цогцолборыг багтааж байгаа учраас ойролцоо утгын тогтолцоо гэдэг нэр томъёон дор хэрэглэх учиртай гэж үзэж байна. Үе үеийн эрдэмтэн судлаачид ч энэ талаар өөр өөрийн бодол дүгнэлт санаа оноотой байсан билээ.

Энэ тухай монгол хэлний найруулга зүй судлаач Д.Отгонсүрэн, “Синоним гэсэн үг хэлшинжлэлийн утга зохиолд үндсэн хоёр утгаар хэрэглэгдэж байна. ... зөвхөн ойролцоо утгатай үг төдийгүй ойролцоо утга илэрхийлдэг хэлний аливаа арга хэрэглүүр болох ойролцоо утгатай өгүүлбэр, хэвшмэл хэлц, дагавар нөхцөл зэргийг багтааж байгаа тул ойролцоо утгатай үгээс маш өргөн утгаар хэрэглэгдэж байна. Үүнийг хэлний зүйн арга хэрэглүүрийн ойролцоо утга буюу ойролцоо утгат арга хэрэглүүр гэж ойлгоод, ойролцоо утгат үг, ойролцоо утгат өгүүлбэр, ойролцоо утгат дагавар нөхцөл гэх мэтээр нэрлэж болох...”<sup>4</sup> гээд Монгол ардын дуу “Сүнжидмаа”-гаар жишээ авч бичжээ. Тэр дууны эхний бадагт байгаа “ арвуулаа болоод хориулаа” гэсэн тоо сүүлийнхэд нь байгаа “ хориулаа болоод гучуулаа” гэсэн тооноос бодит утгаараа ялгаатай боловч энэ дуунд олуулаа гэсэн нэг л утга илэрхийлсэн бол хоёр бадагт байгаа арван хэд хонолоо, хорин хэд хонолоо гэсэн хэллэг ч олон хоног хүлээсэн гэсэн ойролцоо утга бүхий эх сэдвийн синоним болно.” гэжээ.

Судлаач, проф. Н.Нансалмаа, “Үгийн сангийн нэгжүүд хувилбартай байх хоёр дах төрлийн харьцаа нь үгийн сангийн нэгжүүдийн хооронд илрэх ойролцоо утгын харьцаа юм. Энэ харьцааны үед үгийн дотоод хэлбэр – утгалбар харьцангуй тогтвортой байхад энэ утгыг илэрхийлэгч үгийн гадаад хэлбэр буюу үглэвэр хувилбартай байна.”<sup>5</sup> гэжээ.

2. Б.Пүрэв-Очир, 2000, “Орчин цагийн монгол хэлний өгүүлбэр зүй” 2, 166 дах тал

3. П.Бямбасан, 1982, “Орчин цагийн монгол хэлний синоним”, [Монгол хэлний онол, бүтцийн асуудалд] Уб., 360-67 дах тал

4. Д.Отгонсүрэн, 1998, “Ойролцоо утгат үгийн найруулгын үүрэг”, [Монгол хэлний үгийн сангийн найруулга зүй], Уб., 37 дах тал

5. Н.Нансалмаа, 2005, “Үгийн гадаад хэлбэр хувилбартай байх нь”, [Үгийн сан судлал], Уб., 96-100 дах тал

Ойролцоо утгат бүтээврийн тухай. Монгол хэлэнд хэлзүйн язгуур, нөхцөл, дагавар бүх бүтээврүүд ойролцоо утгатай байж болно. Үүнийг олон эрдэмтэн судалгааны бүтээлдээ хүлээн зөвшөөрдөг. Профессор Ц.Өнөрбаян, "...би, миний – гэсэн хэлзүйн хоёр үгийн бүтэц дэх би, ми- хоёр нь хэлбэр, байраараа бие биеэ үгүйсгэвч, гүйцэтгэх үүргээрээ (нэгдүгээр биеийг төлөөлөн) бие биеэ нөхөж байгаа тул нэг язгуурын хоёр хувилбар ... болох жишээтэй. Нөхөх байрлалд байгаа хоёр бүтээвэр нь нэг бүтээврийн хувилбарууд болно." гэснээс үүдэж эдгээр бүтээвэр ойролцоо утгатай учраас хэлний нэг бүтээврийн хувилбарууд болж байна гэж үзэж болох юм.

Профессор М.Базаррагчаа, "хэлний нэгжүүдийн хоорондох харьцаа"-г ойролцоо, эсрэг, төсөөт, зүйлчилсэн гэж 4 хуваагаад "ойролцоо бүтээвэр (утгалвар, утгат хэсэг) –дал, -ц (-dal, ca) яв-дал, яв-ц, суу-дал, суу-ц, бай-дал, бай-ц, (байр байц), буу-дал, буу-ц, гүй-дэл, гүй-ц, -дал, -аас, (dal, la-su): оё-дол, оё-оос, зур-дал, зур-аас,"<sup>6</sup> гэж жишээ авсан байна.

Судлаач, Б.Бямбадорж, "Нэг бүтээврийн утга нөгөө бүтээврийн утгатай ойролцоо байх нь язгуур, дагавар, нөхцөл бүтээврийн алинд ч хамаатай байна."<sup>7</sup> гээд монгол хэлний язгуур (ца-цан, цас, цаас, цавь, цавьдар, цагаа, цагаагч, цагаан, цал, цахиур, цагаавтар; хя- хяруу, хярам, хяраа, хялай, хялман, хярмаг, хиурс), дагавар (-дол, -оос, -оо: оёдол, оёос, оёо), нөхцөл (-магц<sup>1</sup>, -нгуут<sup>1</sup>, -саар<sup>1</sup>) бүтээвэр, сул үг буюу өгүүлбэрийн нөхцөл (уу, үү, бэ, вэ)-ийн ойролцоо утгыг жишээгээр батлаж бичжээ.

Ойролцоо утгат дагавар, нөхцөлийн тухай. Монгол хэлний хувилбар бүхий бүх нөхцлийг ойролцоо утгатай гэж үзэж болно гэж дээр дурдсан. Энэ өгүүлэлийг урт болгохгүйн тулд товчлон авч үзье. Үүнд хувилбар бүхий тийн ялгалын нөхцлүүд (-ы, -ий, -н, -ын, -ийн, -аар<sup>1</sup>, -аас<sup>1</sup>, -г, -ийг, -ыг, -той<sup>3</sup>, -лугаа<sup>2</sup>, -руу<sup>2</sup>) тухай тухайн тийн ялгалдаа ойролцоо утга бүхий хувилбартай байна. Мөн ерөнхийлөн хамаатуулахын –аа<sup>4</sup> нөхцөл ойролцоо утгатай. Олон тооны нөхцлүүд (-ууд<sup>2</sup>, -уул<sup>2</sup>, -д, -нар<sup>2</sup>, -с, -чууд<sup>2</sup>, -чуул<sup>2</sup>) хэдийгээр бие биеийн байранд тохиолдохгүй ч ойролцоо утгын үүрэг гүйцэтгэнэ. Тэмдэг нэрийн утга эрчимжүүлэх болон бууруулах дагаварууд (-втар<sup>1</sup>, -дуу<sup>2</sup>, -нгий<sup>2</sup>, -хан<sup>1</sup>, ), тооны нэрийн дагаврууд (-дугаар<sup>2</sup>, -дах<sup>2</sup>; -аад<sup>1</sup>, -орчим; удаа, дахин;), үйл үгийн хэвийн нөхцлүүд (-уул<sup>2</sup>, -лга<sup>1</sup>, -га, -аа<sup>1</sup>, -гд, -д, -т, -лд, -лц, ), үйл үгийн байдлын айн нөхцлүүд (-чих, -ч, -ж орхи-, ; -схий, -зна<sup>1</sup>; ), үйл үгийн тодотгон холбох нөхцлүүд (-лаа<sup>1</sup>, -сан<sup>1</sup>, -в; -), үйл үгийн нөхцөлдүүлэн холбох нөхцлүүд (-ж, -ч, -аад<sup>1</sup>, -н, ), угсруулан холбох нөхцлүүд (-магц<sup>1</sup>, -тал<sup>1</sup>, -хлаар<sup>1</sup>, -вал<sup>1</sup>, -бал<sup>1</sup>; -сан юм бол, -нгаа<sup>1</sup>, -х зуур, -х замдаа, -нгуут<sup>2</sup>, -магц<sup>1</sup>, -уут<sup>2</sup>, -сан дор, -хлаар<sup>1</sup>, -саны дараа, ), үйл үгийн цагаар төгсгөх нөхцлүүдийн нийлэг ба задлаг хэлбэр (-на<sup>1</sup>, -ж байна; -жээ<sup>2</sup>, -лаа<sup>1</sup>, -в; ), биеэр төгсгөх нөхцлүүд (-я<sup>1</sup>, -муй<sup>2</sup>, -мү<sup>2</sup>, -на<sup>1</sup>, -на<sup>1</sup> уу<sup>2</sup>; -гтун<sup>2</sup>, -тугай<sup>2</sup>, -уузай<sup>2</sup>, -ж болохгүй, -аасай<sup>1</sup>, -даг<sup>1</sup> болоосой, -хыг хүсэж байна; -аач<sup>1</sup>, -аарай<sup>1</sup>; ) төлөөний үгс (би, ми-, на-; чи, та, өөрөө; өд, өчнөөн, төд, төчнөөн, өчнөөн төчнөөн; энэ, үүн; тэр, түү-; аль, ямар; яагаад, хэрхэн; хэд, хэчнээн; бүх, цөм, булт, бүгд, бүх, хамаг, даяар, хотол, ; өөр, бусад, нөгөө; ), холбох үгс (ба, буюу, бөгөөд, болон, болоод, өөрөөр хэлбэл, ; гэтэл, гэвч, гэлээ ч, гэсэн ч, тэгтэл, тэглээ ч гэсэн, харин, авч, атал, нэг бол, эсвэл; бас, мөн, үүнчлэн, тэрчлэн, түүнчлэн, мөн түүнчлэн, түүгээр барахгүй, төдийгүй, тэр байтугай, түүгээр үл барам, ; иймээс, иймийн тул, ингэхлээр, ингээд, тиймээс, тийм учраас, тиймийн тул, ; учраас, улмаас, -ын дагуу, -зэрэгцээ, ) чимэх үгс (эрчимжүүлэх утгат: маш, нэн, тун, улам, час, цоо, пиг, пад, ;дүрслэх утгат: хага, хуга, бут, бяц, няц, дэлбэ, огло, гуд,... батлах утгат: шүү, даа, даг, юм, мөн, лав, барагцаалах утгат: биз, шив, бий, маягтай, асуух утгат: вэ, бэ, уу, үү, юу, юү, үгүйсгэх утгат: бүү, битгий, хэрэггүй, ёсгүй: үл, эс, биш, үгүй, бус, онцлох утгат: ч, л, ) бүгд ойролцоо утгатай байж болно гэж үзэж болох юм. Эдгээр үгс нь ерөнхий утгын хувьд л ойролцоо утгатай байхаас бус утгын нарийн ялгамж, нэмэлт утга, баймж утгын хувьд бие биеэсээ бага боловч ялгарч байдаг.

6. М.Базаррагчаа, 2005, "Монгол хэлний өгүүлбэр судлал", Уб., 56 дах тал

7. Б.Бямбадорж, 2011, "Орчин цагийн монгол хэлний хэлбэр судлал", 28 дах тал

Монгол хэлний ойролцоо утгатай нөхцлүүдийн хөгжлийн тухай д-р Ц.Өнөрбаян, “үйлийн нөхцөлдүүлэн холбох зарим нөхцлүүд нөгөө нөхцөлтэйгээ ойролцоо утгатай болж аль нэг нь хэрэглээнээс шахагдаж идэвхигүй болсон тохиолдол ажиглагдаж байна. Тухайлбал, -бал, -хлаар хоёр, -нгуут, -магц хоёр тус бүр ижил утга, үүрэгтэй болсон байна. Үүнээс үзвэл үйлийн нөхцөлдүүлэн холбох нөхцөлүүдийн тоо цөөрч, зарим нөхцөлүүдийн хэрэглээ хязгаарлагдаж, зарим нь утга үүргээрээ идэвхжиж байгаа зүй тогтол ажиглагдаж байна” гэж тайлбарлажээ. Мөн “Академич Ш.Лувсанвандан бээр, “Хэлний дохио хэлбэр нь хэвээрээ байвч утга нь янз бүр болох, хэлбэр нь янз бүр боловч утга нь хэвээрээ байх удаа арвин тохиолдоно.”<sup>8</sup> гэжээ.

Эдгээр нөхцлүүд нь яагаад ойролцоо утгатай вэ гэдгийг онолын үүднээс тайлбарлахад хэлний нөхөх, үл нөхөх зарчмын онлыг ашиглаж болно. Энэ тухай дурдаж тайлбарласан эрдэмтэд ч байдаг. Тухайлбал проф. Ц.Өнөрбаян, “Хэлний хоёр өөр хэлбэртэй утгат хэсгийг нэг бүтээврийн хоёр хувилбар уу, эсвэл тус тусдаа бие даасан хоёр өөр бүтээвэр үү гэдгийг тогтоох хэд хэдэн шалгуур байдаг. Үүнд, адил утгатай (ойролцоо утга ЖБ) эсэхээр нь ялгаж болно. Хэрэв адил утгатай байвал нэг бүтээврийн хоёр хувилбар, өөр өөр утгатай байвал хоёр бие даасан бүтээвэр болно. Жишээлбэл, -аар, -ээр гэсэн хоёр хэлбэр нь нэр үндсэнд орохоороо үйлдэхийн утга илтгэж, голдуу нэр, үйлийн харьцаа заах тул нэг бүтээврийн хувилбар болно.”<sup>9</sup> гэж үзсэн бөгөөд энд дурдагдаж байгаа “нэг бүтээврийн хувилбарууд”-ыг бүгд ойролцоо утгатай байж болно гэж үзэж болох юм. Энэ бол хэлний аливаа үзэгдэл тэр дундаа ойролцоо утгатай эсэхийг хэлний нөхөх, үл нөхөх байрлалын зарчмаар ч ялгаж болно гэсэн үг юм.

Академич Ш.Лувсанвандан, энэ тухай аль 70-аад оны сүүлээр дэлгэрэнгүй дурдсан бий. Тэрбээр, “Байрлал хэлшинжлэл нь нэг адил фонем буюу морфемын янз бүрийн хувилбар болох уу, эсвэл тус тусдаа биеэ даасан өөр өөр фонем буюу морфем болохыг зохих фонем, морфемын байрлалаар тогтоох аргыг боловсруулсан байна. Энэ аргын ёсоор бол ямарваа хоёр авиа нэгийгнээ тохиолдох байранд нөгөө нь тохиолдохгүй байвал тэр хоёр авиа нэг фонемын хоёр хувилбар байж, тэгж тохиолдож байвал тус тусдаа биеэ даасан хоёр фонем болох ёстой ажээ. Биеэ даасан тус тусдаа морфем буюу нэг морфемын янз бүрийн хувилбар болохыг мөн аргаар ялган тогтоох болсон байна.” гэж бичсэн бөгөөд “Хоёр элемент нь хэлбэр, байрын талаар харилцан бие биеэ үгүйсгэвч гүйцэтгэх үүргийн талаар харилцан бие биеэ нөхөж, нөхөх байрлалд, дан хэлбэр, дан байр, эсвэл хэлбэр, байр хоёроороо бие биеэ үгүйсгэвч гүйцэтгэх үүргийгнээ талаар харилцан нөхөхгүй байвал үл нөхөх байрлал”<sup>10</sup> гэх бөгөөд үүгээр үзвэл нөхцлийн хувилбарууд бол хэлбэр байр хоёроороо бие биеэсээ ялгарлаг билээ. “Хэлний аливаа хоёр элемент нь байрын талаар харилцан бие биеэ үгүйсгэвч нэг нь нөгөөгүйгээр байж болохгүй, нэг бүхэл зүйлийн хоёр тал болж харилцан бие биеэ нөхөж байвал тэр хоёр элемент нь заавал нэг ерөнхий дундаж утга, үүрэгтэй байдаг байна.” гэдэг онолын дагуу монгол хэлний нөхцөл ойролцоо утгатай байж болно хэмээн тодорхойлж байна.

Монгол хэлний нөхцөл, лагавар ойролцоо утгатай байж болох тухай монгол судлаач эрдэмтэд ажиглаж тэмдэглэж ирсэн бөгөөд тухайлбал, монгол хэлний өгүүлбэрзүй судлаач эрдэмтэн Б.Пүрэв-Очир үүнийг мөн ажиглаж “Монгол хэлний нэр үг, бас үйл үгийн холбох ба төгсгөх нөхцлийн анги бүлэгт ойролцоо утгатай нөхцөл бас олон бий. Жишээ нь Намайг хэлтэл ойлголоо, намайг хэлмэгц ойлголоо гэдгийн –тэл, -мэгц хоёр тун ойролцоо утгатай байгаа, бас намайг хэлэнгүүт ойлголоо, намайг хэлэхтэй зэрэг ойлголоо гэхэд –нгүүт нөхцөлд, зэрэг гэдэг задлаг холбох хэрэглүүртэй маш ойролцоо утга илтгэж байгаа юм. Харьяалах тийн ялгалын –ийн, -ын, хувилбарын утгатай, дах, дэх гэдэг задлаг хэлбэрийн утга нь бараг дүйдэг. Жишээ

8. Ш.Лувсанвандан, 1980, “Хэл түүний нэгжүүдийн хувирах тогтох тухай асуудал”, [Монгол хэл шинжлэлийн асуудлууд] Уб., 16-17 дах тал

9. Ц.Өнөрбаян, 2004, “Орчин цагийн монгол хэлний үг зүй”, Уб., 93-94 дэх тал

10. Ш.Лувсанвандан, 1969, “Хэлний нөхөх, үл нөхөх байрлалын тухай асуудал”, [2010. Хэлшинжлэлийн онолын асуудлууд, Уб., 128-137 дах тал]

нь: энгэрийн одон, энгэр дэх одон, тал дах ганц айл, талын ганц айл гм.”<sup>11</sup> хэмээн бичжээ.

Орчин цагийн монгол хэлний олон тоо заах залгаварууд нь утгын хувьд хоорондоо ойролцоо утгатай гэж өмнө бичсэн. Хэдийгээр энэ залгаварууд хэлзүйн тогтолцооны үүднээс нэг нь нөгөөгийн байранд тохиолдох, эс тохиолдох хоёр байдалтай боловч олонх тохиолдолд бие биеийхээ байранд эс тохиолдох бөгөөд олон тооны утга илтгэх тэр утгаараа хоорондоо ойролцоо утга илэрхийлж болно гэж үзэж байна. Үүнд, -ууд, нар, -д, -чууд, -чуул, -уул, -с, зэрэг залгаварууд багтана. Тухайлбал уул гэдэг үгийн хувьд уулс, уулууд гэдэг хоёр тохиолдол байж болох боловч бусад нөхцлүүд олны утга заах үүргээрээ тохиолдох боломжгүй юм. Харин тооны айн залгаварыг үг бүтээх дагавар уу, эсвэл үг хувилгах нөхцөл үү гэдэг дээр зөрөөтэй саналууд бий. Профессор Ц.Өнөрбаян, “... хэлний хэлбэрүүдийн тоо олшрох тутам хэлний тогтолцоонд эвдрэл буюу эрэмбэгүйдэл үүсч дээд цэгтээ хүрч эргээд тоо нь аяндаа цөөрч тодорхой нэг хэлбэр нь утга, үүргээрээ давамгайлан өөрөө цэгцэрдэг хууль үйлчилдэг байна. Орчин цагийн монгол хэлэнд олон тооны нөхцөлүүдийн тоо, утга үүрэгт эрэмбэгүйдэл (хаос) үүсч эргээд цэгцрэх шатандаа орж байгаа байдал ажиглагдаж байна. Ялангуяа –ууд<sup>2</sup>, нар нөхцөлүүд бусад хэлбэрээ шахаж байгаа баримт түгээмэл тохиолдож байна.”<sup>12</sup> гэжээ.

“Бүтэц өгүүлбэрийн дотор харьцаанд орсон хэлбэржсэн үгэнд ч синоним (ойролцоо утга, солин найруулах боломж) гардаг. Жишээ нь: Би, тантай уулзахаар (уулзах гэж) ирлээ гм. Энэ бол хэлзүйн синоним юм. Тэгэхлээр хэлбэржсэн үгэнд ойролцоо утга байдаг.”<sup>13</sup> гэж мөн үзэж болно.

Ойролцоо утгатай гадаад дотоод холбоос буюу баймж үгийн ойролцоо утгын цувааг авч үзвэл: (ойролцоо утгатай холбоосуудыг ; цэгтэй таслалаар зааглав) ба, бөгөөд, агаад, хийгээд, болов; ийн, ийнхүү, тийн, тийнхүү, үүнээс уламлан, мөн түүнчлэн, түүнчлэн, үүний хамт, үүний зэрэгцээ, үүний зэрэгцээ(гээр). ; ийм учраас, ингээд, иймийн тул(д), үүний тул, тийм учраас, тийм ч учраас, тийм дээрээс, тийм учир дээрээс, тиймийн тул; мөн, мөнхүү, бас, басхүү, мөнхүү, түүнээс гадна, харин бас, цаашилбал, ; харин, гэхдээ, гэтэл, гэсэн ч, гэлээ гэхдээ, гэлээ гэсэн ч, гэлээ ч, -лаа<sup>1</sup> ч, ; хэрэв, хэрвээ, хэрэвзээ, хэрэв тэгвэл, тэгэхэд хүрвэл, тийм бол, тийм юм бол, ; ялангуяа, тэр тусмаа, ; байтугай, учир нь, юу гэвэл; тэр ч байтугай, төдийгүй, түүгээр үл барам, үүнээс гадна, үүнээс өөр, -аар<sup>1</sup> бүл барам, -аар<sup>1</sup> зогсохгүй, ; аль эсвэл, эсвэл, эсхүл, нэг бол, үгүй бол ; энэ мэт, энэ мэтчилэн(гээр), ; нөгөө талаар, түүнээс гадна, өөрөөр хэлбэл, буюу, ондоогоор хэлбэл, нэг үгээр хэлбэл, нөгөө үгээр хэлбэл, нөгөөгөөр хэлбэл, өөр утгаар хэлбэл, нөгөө утгаар хэлбэл, ; нэн ялангуяа, даа ялангуяа, ; -ын ёсоор, -ын дагуу, ; харин ч, тэгж ярьвал, -ын даваан дээр, -ын толгой дээр, -х үед, -ын алдад, ; тэгээд ч, ; -ын цагт, - хаа тулбал, ; үнэхээр, үнэндээ, үнэн хэрэг дээрээ, үнэн хэрэгтээ, үнэнийг хэлэхэд, үнэнхүү, хэрэг дээрээ, үндсэндээ, угтаа, аргагүй, нээрээ, ; гэх мэтээр хэлний хөгжлийн явцад цөөрч, задарч, нийлж хөгжих боломж бий.

Хэлний дотоод гадаад холбох үгсийн ойролцоо утгын тухай профессор Б.Пүрэв-Очир, “... монгол хэлний өөрөөр хэлбэл гэдэг нийлэмжийг үүсмэл, нийлмэл бүтэцтэй, гол нь тодосгогч-тодосгуулагч хоёрыг онцлох, тайлбарлах утгатай, ондоогоор хэлбэл, нэг үгээр хэлбэл, нөгөө үгээр хэлбэл, нөгөөгөөр хэлбэл, өөр утгаар хэлбэл, нөгөө утгаар хэлбэл гэх мэт солин найруулах боломжтой хэд хэдэн хувилбартай, оруулбар нэгжийн байдалтай хэрэглэгддэг, тайлбарлах утга бүхий холбох үг гэж үзэж байна.”<sup>14</sup> гэсэн тодорхойлолтод байгаа солин найруулах боломж гэдгийг бол утга тэнцүү буюу ойролцоо гэсэн үг, хэд хэдэн хувилбар гэдгийг ойролцоо утгатай хэд хэдэн хувилбар гэсэн үг, гэж ойлгож болох юм.

11. Б.Пүрэв-Очир, 1998, “Монгол хэлний өгүүлбэрзүй 2”, Уб., 151 дэх тал

12. Ц.Өнөрбаян, 2004, “Тооны ай”, [Орчин цагийн Монгол хэлний үг зүй], Уб., 186-96 дах тал

13. Б.Пүрэв-Очир, 1998, “Монгол хэлний өгүүлбэрзүй 2”, Уб., 151 дэх тал

14. Б.Пүрэв-Очир, 2005, “Монгол хэлний өөрөөр хэлбэл гэдэг холбох үгийн бүтэц, утга, үүрэг, хэрэглээ”, [Acta Mongolica], Уб., 57-59 дэх тал

Үг бүтээх дагавар, хэлзүйн нөхцөл ойролцоо утгатай байж болно гэдгийг эрдэмтэд хүлээн зөвшөөрсөөр буй. Монгол хэлний өгүүлбэрийн холбоосыг бүртгэн судалсан эрдэмтэн Б.Пүрэв-Очир, “Монгол хэлний гөжүүн, гөжүүд гэх мэт тэмдэг нэрийн –үүн, –үүд дагавар синоним дагавар болно. Энэ мэт дагаврын анги бүлэгт ойролцоо утгатай бүтээвэр өдий төдийгөөрөө бий.”<sup>15</sup> гэжээ.

Монгол хэлний ойролцоо утгатай дагавар, нөхцлүүдийн хөгжил нь хэлний хөгжлийн хуультай зайлшгүй холбоотой. Хэл бол байнга хөгжиж өөрчлөгдөж байдаг хөдөлгөөнтэй зүйл учраас нэг дагавар нөхцөл шахагдан үгүй болоход нөгөө дагавар нөхцөл түүнийг орлон үүсч байдаг билээ. Тэр орлон үүсч байгаа дагавар нь ойролцоо утгат хувилбар байдаг гэж хэлж болно. Монгол хэлний нөхцлийн гарал хувьсал, өөрчлөлтийг судалсан эрдэмтэн М.Саруул-Эрдэнэ бээр, “Ер нь аль ч хэл хувьслынхаа явцад улам илүү хөгжиж байгаа бөгөөд “хөгжил” гэдэгт зөвхөн хэлний хэмнэл, авиа гээгдэх, өгүүлбэрийн гишүүн хураагдах ёсыг авч үзэх нь учир дутагдалтай юм. Зарим нөхцөлийн үүргийг задлаг хэрэглүүрүүд гүйцэтгэж буй болон авиа нэмэгдэх зэрэг дээрхийн эсрэг үзэгдэл ч мөн хэлийг боловсронгуй болгож байгаа билээ.”<sup>16</sup> гэжээ. Тэрбээр цааш нь нөхцөл бүтээврийн тухай дурдахдаа, “Нөхцөл бүтээвэр үндсэндээ шингэх. Энэ нь бараг бүх нөхцөлдүүлэн холбох нөхцөлүүдэд тохиолдож буй хувьсал бөгөөд царцан хэвшсэн ихэнх үг нь холбох үгс байна. Монгол хэлний үйлийг үйлтэй холбох үндсэн үүрэг бүхий дээрх нөхцлүүд нь цаашид задлаг хэлбэрүүдэд байраа алдах, хэрэглээнээс шахагдах хандлагатай байна. Тухайлбал, -саар = -аад л, -ж л, -ж –ж, -вал = бол, болбол, -вч = боловч, ч гэсэн, гэхдээ, гэвч, -тал = хүртэл, болтол, -нгаа = -х зуураа, - х замдаа, -нгуут, -магц = -хтай зэрэг, -сан дороо, -хаар = -х гэж, -хын тулд зэрэг задлаг-нийлэг-задлаг гэсэн дарааллаар хөгжих хэлний эволюци хувьслын үл сарних хэлбэлзлийн дагуух үзэгдэл юм.” гэжээ.

Монгол хэлний баймж үг ойролцоо утгатай байж болно. Монголч эрдэмтэн Г.Ц.Пюрбеев, “Объектив хэлхээ холбоог тусгасан баймж чанарын нэг төрөл зүйл нь бодит баймж утга юм. Энэ нь цаг заах төлөвийн хэлбэр болон нээрээ, үнэхээр, үнэнээр, үнэн хэрэг дээрээ, чухам, чухамдаа ... зэрэг ойролцоо утга бүхий үг, холбоо үгийн илтгэцүүдээр илэрдэг.”<sup>17</sup> гэжээ. Ийнхүү монгол хэлэнд ойролцоо утгатай баймж үг хөгжих боломжтойг доорх жишээнээс харж болно. Үүнд, хэн хүнгүй, хэн янгүй, хэн ч, хүн бүр, бүгд, бүх хүн, ямар ч хүн, дурын хүн, аливаа хүн, ямарваа хүн : хэзээ хэзээгүй, мөд, мөдхөн, хэзээ язаагүй, даруй, : хэзээнээсээ, хуучны, бүр дээрээс, : хэзээ боловч, хэзээ ч, хэзээд, байнга, үргэлж, ямагт, дандаа, ; хэрхэвч, яавч, яасан ч, ерөөсөө, : үнэхээр, үнэндээ, үнэн хэрэгтээ, үнэнийг хэлэхэд, үнэнхүү, хэрэг дээрээ, үндсэндээ, аргагүй, нээрээ; мэдээж, мэдээжээр, мэдээж хэрэг, мэдээжийн, мэдээжийн хэрэг, ; чухам, чухамдаа, чухамхүү, : ер, ер нь, ер нь л, ер нь ч, ерөөс, ерөөсөө, ерөөсөө л, ердөө ч, ердөө л, ерөнхийд нь, ерөнхийдөө, ерөнхийдөө л, ; уг нь, уг нь л, угаасаа, угаасаа л, угаасаа ч, уул нь, зүй нь, угтаа ч, уг чанартай, уул шугамандаа, уул ухаандаа, мөн чанартай; заавал, заавал ч үгүй, зайлшгүй, зайлбаргүй, гарцаагүй; яав ч, яав чиг, ; эрхгүй, өөрийн эрхгүй, өөрийн мэдэлгүй, ; зохино, зохилтой, зохистой, хэрэгтэй, ; ядахдаа, үгүй ядахдаа, ядаж, ядахнаа, гэх мэт асар өргөн боломж бий.

Монгол хэлний баймжийн айг судлаач д-р Ю.Мөнх-Амгалан монгол хэлний баймж үгийг судалгаа хийх явцдаа “Ер нь янз бүрийн баймж утга бүхий монгол өгүүбэрүүд нь хувиргалын харьцаанд оршдог.. тул бид хэлэхүйн болон харилцааны түвшинд солин хэрэглэж болох хувилбар хэлбэрүүдийг дор бүр нь дурдаж гаргахыг оролдов.”<sup>18</sup> гээд тухай тухайн баймж үгсийн ойролцоо утгыг нэлээд нэмж, утгыг тодруулан тусгайлан зааж, жишээ баримт хадаж

15. Б.Пүрэв-Очир, 1998, “Монгол хэлний өгүүлбэрзүй 2”, Уб., 151 дэх тал

16. М.Саруул-Эрдэнэ, 2007, “Монгол хэлний нөхцөл бүтээврийн үгзүйн түүхэн хувьсал”, Уб., 7 дах тал

17. Г.Ц.Пюрбеев, 1981, “Категория модальности и средства её выражения в монгольских языках”, Москва., №5, 25-30 дах тал

18. Ю.Мөнх-Амгалан, 1998, “Орчин цагийн монгол хэлний баймжийн ай”, 85-86 дах тал

өгсөн байдаг. Тухайлбал, асуух төлөөний үгийн судалгаандаа, “Хэн хүн гэдэг нь өгүүлбэрт тодорхойгүй төлөөний үгийн үүргээр орж хүн болгон, захын хүн, тэр болгон хүн, хүн тэр болгон, хэн хүнгүй, хэн янгүй, хэн хүнгүй ... зэрэг хам бүтцээр солин хэрэглэж болдог байна. ... Хэн хэнгүй, хэн хүнгүй, хэн янгүй, хэн ч гэсэн зэрэг хэлбэр нь хүн бүр, бүгдээр(ээ), аливаа хүн, ямарваа хүн, ямар ч хүн гэсэн гэх мэт ойролцоо утга илэрхийлдэг.”<sup>19</sup> гэж чухам ямар ямар ойролцоо утгаар сольж хэрэглэж болох боломжтойг зааж өгчээ.

Монгол хэлний үг, хэллэг ойролцоо утгатай байж болно. Ерөнхий хэл шинжлэлд “дуудлагаараа өөр боловч утгаараа төсөөтэй буюу нэн ойр үгсийг ойролцоо үгс гэнэ” гэж нэрлэдэг бөгөөд бид “бичлэг дуудлагаараа ялгаатай боловч утга илэрхийлэх шинжээрээ ойролцоо үг хэллэгийг ойролцоо утгат үг хэллэг гэнэ” гэж тодорхойлдог. Жишээлбэл, авирах, мацах, асах, өгсөх, бэлдэх, зэхэх, төхөөрөх, дэлхий, ертөнц, хорвоо, орчлон, мэдэх, ойлгох, ухах, таних, ойх, унтах, нойрсох, хажуулах, хөгшин, буурай, өтөл, настан, өвгөн, төгцөг, зөнөг, хурдан, бушуу, түргэн, үтэр, шалав, эцэх, цуцах, чилэх, алжаах, ядрах, зүдрэх, зовох гэх мэт.

Хэл хөгжихөд нэг ухагдахуун утга санааг зүйл бүрээр илэрхийлэх арга боловсрох сацуу үгийн санд утга сүлбээт үүр үгс бий болдог. Энэ нь туйлын буюу яг тэнцүү чанарт хоёр буюу хэд хэдэн үг нэг хэлэнд байдаггүй, тийм хэрэгцээ шаардлага ч гарах боломжгүй гэсэн үг юм. Тийм учраас утгаараа бүрэн ба бүрэн бус нийлж байгаа үгс бол ойролцоо утгат үг болох юм. Бас нөгөө талаас нь эхийн утгыг өөрчлөхгүйгээр харилцан бие биеийг орлуулж болдог үгсийг ойролцоо утгат үг гэнэ гэж тодорхойлж болно.

Аль ч хэлний үгийн сангийн бүх үгс ойролцоо утгыг бүрдүүлдэггүй. Харин ихэнхи нь үйлийн утга заасан, чанар тэмдгийг илэрхийлсэн байх бөгөөд бусад хэлэнд ч адилхан байдаг. “Монгол хэлний ойролцоо утгатай үгийн санг авч үзвэл ихэнхи нь ойролцоо утгатай үйл үг байдаг бөгөөд монгол хэлний ойролцоо утгат үйл үгсийн тухай асуудал нь үгийн сан, утга судлалтай нягт холбоотойгоос гадна найруулга зүй, утга зохиолын онолтой хүртэл холбогдох өргөн дэлгэр ойлголт юм.”<sup>20</sup> Ойролцоо утгат үг хэллэг нь үүргийн хувьд маш нарийн утгыг товойлгох, үйл явц, байдлыг илэрхийлдэг бол найруулгын хувьд маш олон өнгө аясыг илэрхийлдэг сэтгэхүйтэй нарийн холбоотой юм. “Монгол хэлэнд үгийн сангийн ба эх сэдвийн ойролцоо утгатай үгс үлэмж олон, маш сонин зүй тогтолтой. Эдгээр нь үгийн сан, найруулга зүй хоёрыг холбон нөхцөлдүүлж байдаг. Жишээ нь: аажим-алгуур-удаан-тайван-уужуу гм. Энэ үгс нь найруулгад ялгамжтай утга гаргаж хэрэглэгддэг.”<sup>21</sup> байна.

Монгол хэлний ойролцоо зэргэдийг дагнан судалсан судлаач д-р Б.Мөнгөнцэцэг, ойролцоо үг гэдэг нэр томъёог барин монголч эрдэмтэдийн хэлийг агуулга ба хэлбэр, зогсонги ба хөдлөнги талаас нь судалсан судалгааг түшиглэн мэдэгдэхүүн, мэдэхүүн, хэлэхүүн, хэлэгдэхүүний хүрээнд туйлын, оновчтой, оновчтой бус, хуурмаг ойролцоо үг гэж ангилан судалж, мэдэгдэхүүний талаас нь бодит утга бүхий туйлын ойролцоо үг, бодит утга бүхий оновчтой ойролцоо үг, хэлэгдэхүүний талаас хийсвэр утга бүхий туйлын ойролцоо үг, хийсвэр утга бүхий оновчтой ойролцоо үг, хэлэхүүний талаас хийсвэр утга бүхий оновчтой бус ойролцоо үг, хийсвэр утга бүхий хуурмаг ойролцоо үг, мэдэхүүний талаас бодит утга бүхий оновчтой бус ойролцоо үг, бодит утга бүхий хуурмаг ойролцоо үг<sup>22</sup> гэж утгыг тус тус маш нарийн ялган үзсэн нь монгол хэлний ойролцоо үгийг утгын хувьд ангилсан судалгааны шинэ үр дүн гэж үзэж болно. Мөн монгол хэлний холбоо үг, нийлмэл үг, хоршоо үг бие даасан утга илэрхийлэх тохиолдолд хэлний

19. Ю.Мөнх-Амгалан, 2007, “Монгол хэлний хэ- язгуурт асуух төлөөний үгийн үүрэг-утгазүйн онцлог”, [МУИС-ийн Монгол судлал ЭШБичиг, №27 (285)] 56-69 дэх тал

20. С.Энхжаргал, 2007, “Монгол хэлний ойролцоо утгат үйл үгийн тухай”, [Монгол хэлшинжлэл], №10 (32), ШУА, ХЗХ, Уб., 91 дэх тал

21. Б.Пүрэв-Очир, 1998, “Монгол хэлний өгүүлбэрзүй 2”, Уб., 151 дэх тал

22. Б.Мөнгөнцэцэг, 2012, “Монгол хэлний ойролцоо үг, түүний утгын ангилал”, [“Монгол хэлний ойролцоо зэргэд”], Уб., 40-74 дэх тал

бусад нэгжтэй ойролцоо утгатай байж болно. Энэ тухай Б.Пүрэв-Очир, “Монгол хэлний чөлөөт холбоо үг болон угсарсан нийлмэл үг, хоршсон нийлмэл үгэнд ч ойролцоо утга олон байдаг. Жишээ нь: загас барих, загас гөхийдөх, загас дэгээдэх, загас гохдох; нутаг ус, нутаг орон; харилцаа холбоо, шуудан харилцаа; хөнгөн тэрэг, суудлын тэрэг гм.”<sup>23</sup> гэж бичжээ.

Ойролцоо үг үүсэх эх үндэс нь юунаас болдог тухай асуудал бол хэлшинжлэлийн сонирхолтой асуудал бөгөөд “Монгол хэлний ойролцоо үг үүсэх эх сурвалжийг нэг талаас бодит юм үзэгдэлтэй шууд холбоо бүхий юмжуулах харьцаанд, нөгөө талаас, юм үзэгдэлтэй шууд холбоогүй, харин юмын шинж чанар, хөдөлгөөнтэй холбоотой дохиожуулах харьцаанд үндэслэдэг гэж үзэж болно.”<sup>24</sup>

Монгол хэлний ойролцоо үгийг судалж, түүний толь бичгийг хийж байх явцад монгол хэлний төрөл бүрийн нэгж хэлбэрүүд ойролцоо утгатай байх бөгөөд тухайлбал, орон заах нэрс ойролцоо утгатай байж болно. Жишээ нь: гадар, гадна, ; хойно, ард; урд, өмнө, урагш; дээр, дээд; гэх мэт. Мөн монгол хэлний чимэх үгс ойролцоо утгатай байж болно. Тухайлбал, утга эрчимжүүлэх үүрэгтэй, маш, нэн, тун, улам, үлэмж, тас, цоо, цав, шив, нов, их гэх мэт үгс ойролцоо утгатай гэж үзэж байна. Энэ тухай өмнө хэсэг дэлгэрэнгүй дурдсан билээ.

Ойролцоо утгыг ярихад төсөөт үгсийг мөн хамт ярьж энэ хоёрыг тодорхой ялгаж салгаж ойлгох хэрэг гардаг. Учир нь ойролцоо утгат үг, төсөөт үг хоёрт төсөөтэй зүйл байдаг учраас зарим судлаачид ялгахгүй байдаг. Гэтэл бас ялгаатай зүйл байдаг учраас ойролцоо үг, ойролцоо утга бүхий төсөөт үг хоёрыг ялгах хэрэгтэй гэж д-р Б.Идэрбаяр нар үздэг. Тухайлбал, гэд “ойролцоо үг нь тэмдэглэхүүн нь өөр өөр, тэмдэглэгдэхүүн нь ойр, бас өөр өөр язгуурт үгс байдаг бол төсөөт үг нь тэмдэглэхүүн, тэмдэглэгдэхүүн хоёр нь хоёулаа ойр буюу ойролцоо, нэг язгуураас эхтэй байдаг, ойролцоо үгсийн үүр нь олон үгээс бүтдэг бол ойролцоо төсөөт үгсийн үүр цөөн үгээс бүрддэг, ойролцоо үгс нь утга ойролцоо дагавраар ялгардаг бол ойролцоо төсөөт үг нь нэмэлт дагавраар ялгардаг” –аараа өөр бол “нэг үгсийн аймагт багтдагаараа, өмнөх үгээ захирах чадвараараа, чөлөөт ба чөлөөт бус найруулгын ялгааг илтгэдэгээрээ ижил”<sup>25</sup> гэж тодорхойлжээ.

Ойролцоо үг бол тус тусдаа эгнээ үүсгэдэгээрээ үгийн сангийн бусад нэгжээс ялгаатай. Тэр тусмаа хоёроос дээш хэдэн ч үгийн үүр үүсгэж болдог онцлогтой бөгөөд гол утга хадгалсан үг нь цөм болж цөм буюу гол үгээсээ холдох тусам нэгэн цуваанд орсон үгийн утга нь гол утгаасаа улам холдон холдсоор явцуурах хандлагатай болдог бас нэг онцлогтой.

Монгол хэлний үгийн аймгийн үүднээс үзвэл бүх үгс ойролцоо утгатай байх боломжтой юм. Үүнд жинхэнэ нэр, тэмдэг нэр, тооны нэр, туслах үгс, аялга үгс, төлөөний үгс, зэрэг багтана.

Ойролцоо утгат үгийн бүрэлдэхүүний хувьд бид ойролцоо утгат үг хэллэгийн бүтэц, утга, үүргийн судалгааны нэг сэдэвт зохиолд монгол хэлний хоршоо үг, өвөрмөц хэлц, хэвшмэл хэллэгийг мөн багтааж үзсэн билээ. Тийм учраас бид үг - үгийн харьцаанд, үг – хоршоо үгийн харьцаанд, үг – өвөрмөц хэлцийн харьцаанд, үг – хэвшмэл хэлцийн харьцаанд, эдгээр нь эргээд бүх бүтцийн харьцаанд ойролцоо утгатай байж болно гэж тус тус ангилсан билээ. Үүнээс хоршоо үг, өвөрмөц хэлц, хэвшмэл хэллэгийн хэлбэр нь ойролцоо утгат хэллэгийн асуудал болох юм. Дээрх харьцааг хоёрын тогтолцоонд авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд: үг - үгийн ойролцоо утгын харьцаа нь хэлэнд хамгийн их хэмжээгээр байх бөгөөд тухайн үгийн үүрийн хувьд хязгааргүй юм. Тухайлбал, (инээх – мишээх, хөхрөх, толгой- тэргүүн, тархи, баруун-өрнө, хойд-умард, зүүн-дорно.) үг – хоршоо үгийн ойролцоо утгын харьцаан (хайрлах – санах сарвайх, мэнд – энх мэнд, мэнд амар, энх тунх, эсэн мэнд, амар мэнд, гм.) үг – өвөрмөц хэлцийн ойролцоо утгын харьцаа (айх – зүрх үхэх, сүлд зайлах, сүнс халирах, сүүлээ хавчих.

23. Б.Пүрэв-Очир, 1998, “Монгол хэлний өгүүлбэрзүй 2”, Уб., 151 дэх тал

24. Б.Мөнгөнцэцэг, 2012, “Монгол хэлний ойролцоо зэргэд”, Уб., 52 дах тал

25. Б.Идэрбаяр, 2005, “Монгол хэлний төсөөт үг”, Уб., 18-19 дэх тал



толгойн үс босох, таван ухаан зайлах гм.) үг – хэвшмэл хэллэгийн ойролцоо утгын харьцаа (даврах – гар бариад бугуй барих, малгай тавиад манайх гэх гм.)

Монгол хэлний өгүүлбэр ойролцоо утгатай байж болно. Үүнийг нэг талаас тайлбарлавал “ойролцоо өгүүлбэр” гэгч нь илэрхийлж байгаа утга санаагаар ойролцоо утгатай болохоос биш түүний бүрэлдэхүүнд оролцсон үг хэллэг нь заавал ойролцоо утгатай байх эсэх тухай асуудал биш билээ. Олон эрдэмтэн ойролцоо утгат өгүүлбэрийг хэлний шууд ба шууд бус нэрлэлттэй холбон тайлбарладаг юм. Гэтэл нөгөө талаас үзвэл ойролцоо өгүүлбэр бүтээх гол хэрэглэгдэхүүн нь ойролцоо утга үг хэллэг байж болно.

Тухайлбал, профессор Б.Пүрэв-Очир, “Өгүүлбэрийг шууд ба шууд бус нэрлэлтийн утгатай гэж ангилж байгаа нь өгүүлбэрийн утгын бүтэц, нэрлэх шинж, хэлэхүйн талтай холбоотой. Шууд ба шууд бус нэрлэлтийн утгатай өгүүлбэрийн харьцаа нь ойролцоо утгатай өгүүлбэрийн асуудалтай холбоотой юм.”<sup>26</sup> хэмээн шууд ба шууд бус утгат үг хэллэгтэй холбон тэмдэглэжээ. Үнэхээр хэлэнд шууд ба шууд бус нэрлэлтийн асуудал ойролцоо өгүүлбэр бүтээх нэг арга мөн боловч ойролцоо өгүүлбэр заавал нэг нь шууд нэрлэлтийнх, нөгөө нь шууд бус нэрлэлтийн байна гэсэн үг биш юм. Харин ойролцоо зэргэд бол голдуу нэг эх буюу цогцолборт тохиолдож болох бөгөөд нэг үйл явдлын тухай, эсвэл үйл явдал нь өөр ч утга санаа нь ойролцоо байхад тулгуурлаж бий болдог зүйл учраас нэг дор тохиолдож болдог.

Ойролцоо өгүүлбэрийн тухай ярихад хувилбар болон бүтэц өгүүлбэр гэдэг ойлголт заавал дагаж яригддаг. Монгол хэлний ойролцоо өгүүлбэрийг хэлний ондооших бас ижилсэх ёсны үүднээс М.Базаррагчаа тайлбарлаж “Ойролцоо өгүүлбэр нь агуулга хэлбэр хоёрыг хослуулан байж бүтэх ба тухайн өгүүлбэрийн хувилбар буюу салаа санаа нь холдон холдсоор ойролцоо өгүүлбэр бий болохын зэрэгцээ, өөр өөр өгүүлбэр ойролцоо санаатай болох ч бий. Үүний эхнийхийг ондооших, сүүлчийнхийг ижилсэх ёс гэж болно.”<sup>27</sup> гэжээ. Мөн М.Базаррагчаа, хэлэхүүний талаас нь монгол хэлний ойролцоо өгүүлбэр бүтэхийг задлан шинжилж “ерөнхий санааг тодорхой, тодорхой санааг ерөнхий санаагаар тус тус давтвал ойролцоо өгүүлбэр бүтнэ, тухайн зэрэгцсэн өгүүлбэрийн хоёроос дээш гишүүд нь ойролцоо үгээр ялгарсан бол ойролцоо өгүүлбэр бүтнэ, хоёулаа нэг санаа илтгэж далд адилтгалаар буюу тойрууллаар бүтнэ, нэг санааг гаргахын тулд тухайн санааг өөр санаатай ил адилтган ойролцоо өгүүлбэр бүтээнэ.”<sup>28</sup> хэмээн тодорхойлжээ. Судлаач Б.Мөнгөнцэцэг, “... өөр өөр өгүүлбэрүүд ижилсэх (конвергенция) буюу нийлэх замаар үүсэн бол ойролцоо өгүүлбэр, нэг өгүүлбэрээс ондооших (дивергенция) буюу салаалах замаар үүссэн бол хувилбар өгүүлбэр болно.”<sup>29</sup> гэж үзжээ.

Монгол хэлэнд ойролцоо утгат эх (цогцолбор) байж болно. Профессор Д.Отгонсүрэн, “Найруулга зүйн синонимын хамгийн өвөрмөц хэлбэр нь эх сэдвийн синоним юм. ... Үгийн сангийн бодит утгаараа адил биш боловч эх сэдэвтэй гүйцэтгэх үүргээрээ ойролцоо үг хэллэгийг, хэллэгээр илэрсэн эх сэдвийн синоним гэж ялгаж болно.”<sup>30</sup> гэж ойролцоо эхийн тухай асуудлыг эхэд байгаа ойролцоо утгат үг хэллэгт хамруулсан байна.

Профессор Б.Пүрэв-Очир, харин “Төрөл бүрийн найруулга дээр ажиглалт хийхэд бичил “эх”-үүд ч ойролцоо утгатай байж болох тохиолдол бишгүй байна. Тухайлбал, монгол ардын “эвтэй дөрвөн амьтан”-ы үлгэрийн бичил эх өгүүлэмж, санааны бүтцийг оросын нэрт зохиолч И.А.Крыловын “Хун, хавчаахай, цурхай гурав”-ын үлгэрийн өгүүлэмж, санааны бүтэцтэй

26. Б.Пүрэв-Очир, 1998, “Монгол хэлний өгүүлбэрзүй 2”, Уб., 155 дах тал

27. М.Базаррагчаа, “Монгол хэлний ойролцоо нэгжийг судлах асуудал”, [Б.Мөнгөнцэцэг, “Монгол хэлний ойролцоо зэргэд, Уб., 2012] 3-16 дах тал

28. М.Базаррагчаа, 2007, “Монгол хэл 9”, Уб., 32 дах тал

29. Б.Мөнгөнцэцэг, 2012, “Монгол хэлний ойролцоо зэргэд, түүний утгын ангилал”, [Монгол хэлний ойролцоо зэргэд], Уб., 89-93 дах тал

30. Д.Отгонсүрэн, 1998, “Ойролцоо утгат үгийн найруулгын үүрэг”, [Монгол хэлний үгийн сангийн найруулга зүй], Уб., 45 дах тал

харьцуулахад нэг дөрөв нь зохилдон эвлэрч, эв эеэ олсноороо, нөгөө гурав нь эс зохилдон эв эеэ ололгүй, хэрэг явдал нь бүтээгүйгээрээ шийдэл нь өөр боловч “эх”-ийн бүтэц, өгүүлэмж, санааны байдлаараа “утга ойролцоо эх”-ийн нэгэн сонин жишээ болж байна.”<sup>31</sup> гэжээ. Ойролцоо утгатай эхийн хувьд монгол ардын дуу, монгол аман зохиолын эхүүд маш тохиромжтой жишээ болдог гэдгийг энд дурдалтай.

Ойролцоо утгат үгийн найруулга зүйн асуудал бол ойролцоо утгын судалгааны салшгүй нэгэн бүрдэл хэсэг мөн. Аливаа эхийн найруулга гэдэг бол хэлний үй олон үзэгдэлийн хамгийн төгс сонголтын үр дүн байдаг гэж хэлж болно. Ойролцоо утгат үгийн найруулгын асуудал бол эх-ийн болон хэрэглээний асуудалтай шууд холбогдоно. Монгол хэл судалсан үе үеийн найруулга зүйч судлаачид энэ асуудалд бас их анхаарч судалж бичиж байлаа. Тухайлбал, С.Лувсанвандан нарын “Монгол хэлний ойролцоо үгийн товч толь”-д “Эр эм ямарваа нэг хүнд эрдэм гэгч нандин чимэг болдогийн адил энэ дэлхийн ямар ч хэлний хосгүй чимэг нь түүний ойролцоо үгс байдаг. Хүн тэр үгсээр санасан санаа, хүссэн хүсэл, бодол эрмэлзлээ гүн гүнзгий, хол тусгалт, нарийн оновчтой, яруу сайхан гаргаж хэлдэг учиртай юм.”<sup>32</sup> гэж ойролцоо үгийн хэрэглээний чухал болохыг заажээ.

Ойролцоо утгат үг хэллэгийн найруулга судлалын асуудал бол ойролцоо утгын хамгийн чухал асуудал билээ. Проф. Д.Отгонсүрэн, “Найруулга зүйн үндсэн асуудлын нэг нь ойролцоо утгатай үгийн найруулгын үүрэг юм”<sup>33</sup> гэжээ.

Найруулга зүйд ойролцоо утгат үгийг хэд хэдэн төрөлд хуваадаг. Тухайлбал, д-р Д.Отгонсүрэн, “Ойролцоо утгат арга хэрэглүүрийг ярианы, найруулга дундын, уран зохиолын гэж үндэн гурван төрлөөр ангилсан ангилал монгол хэлний найруулга зүйн синонимын тухайд ч нэн тохиромжтой байна.”<sup>34</sup> гээд монгол хэлний синонимын найруулгын төрөл, өнгө аясын ялгааг хосоор нь эсрэгцүүлэн ангилжээ.

Д.Нацагдоржийн өгүүллэгийн өгүүлбэрийн найруулгын онцлогийг судалсан профессор М.Базаррагчаа, “өмнөх мөчлөгүүдийн санааг дүгнэсэн байдалтай хоёр өгүүлбэр-мөчлөг нь хэдийгээр алслан салаавчилж орсон боловч бүтцээрээ ойролцоо байна. Жишээ нь, “Хөлд орохоос аваад үс цайхыг хүртэл нэг голыг өгсөн уруудан нүүж, нэг худгийг эргэн тойрон нутагласаар, энэхүү ертөнцийг эцэслэнэ” гэсэн мөчлөг-өгүүлбэрийг “Гагцхүү өглөө бурханд залбирч, үдэш тэнгэрт мөргөсөөр нэг нас барна” гэсэнтэй харьцуулбал, ... өгүүлэхүүнд зэрэгцэж ба угсарч захирагдсан ижил бүтэц давтагдан дотоод гинжин холбоо үүсэх ба нэг... нэг, өгсөн уруудан, эргэн тойрон, өглөө... үдэш, бурхан...тэнгэр, нүү... нутагла-, залбир-, мөргө-..., ертөнцийг эцэслэнэ... нэг нас барна гэх мэтээр нэг үгийг ахих давтах, ойролцоо ба эсрэг үгийг харьцуулан гадаад гинжин холбоо үүсгэн тухайн мөчлөгүүдээр илрэх санааг баяжуулдаг байна.”<sup>35</sup> гэж ойролцоо, эсрэг, ижил үг утгын харьцааг уран зохиолд уранаар ашиглахын бодит жишээг анзааран ийнхүү судалж үзжээ.

Д-р Э.Пүрэвжав, “Эх хэлнийхээ шавхагдашгүй өргөн бололцоо, үгийн сангийн арвин баялгийг бүрэн дүүрэн ашиглаж, ардынхаа уран цэцэн үг хэллэгээс суралцах, эх хэлээ цэвэр байлгахын төлөө байнгад санагалзаж, хэлзүйнхээ дүрэм, ёс горимыг гүнзгий ойлгож мэдэх явдал бол монгол утга зохиолын хэлийг улам боловсронгуй болгоход шийдвэрлэх ач холбогдолтой”<sup>36</sup>

31. Б.Пүрэв-Очир, 1998. “Монгол хэлний өгүүлбэрзүй 2”, Уб., 151 дэх тал

32. С.Лувсанвандан нар. 1966. “Монгол хэлний ойролцоо үгийн товч толь”, Уб., 5-6 дах тал

33. Д.Отгонсүрэн, 1998. “Ойролцоо утгат үгийн найруулгын үүрэг”, [Монгол хэлний үгийн сангийн найруулга зүй], Уб., 36-56 дах тал

34. Д.Отгонсүрэн, 1998. “Ойролцоо утгат үгийн найруулгын үүрэг”, [Монгол хэлний үгийн сангийн найруулга зүй], Уб., 49 дах тал

35. М.Базаррагчаа, 2002, “Д.Нацагдоржийн өгүүллэгийн өгүүлбэрийн найруулгын онцлог”, [Утгын чуулган] Уб., 95-96 дах тал

36. Э.Пүрэвжав, 1996. “Монгол хэлний хэм хэмжээ”, Уб., 13 дах тал

## Ж.Бат-Ирээдүй

хэмээн бичиж байна. Үүнд монгол хэлний ойролцоо үг хэллэгийн мэдлэг, ашиглах хэрэглэх ур чадвар чухал холбогдолтой юм.

Д-р Б.Магсаржав, “Монгол хэлний ойролцоо утгатай үгс найруулгын янз бүрийн түвшинд хэрэглэгддэг. Албан бичгийн найруулгад бүдүүлэг үг буюу этгээд хэллэг хэрэглэхийг хориглох гэх мэт. Энэ мэтчилэн ахуйн хэрэглээний үгс, цэргийн хэргийн хэллэг, нутгийн аялгууны үгс, шинжлэх ухааны хэллэг гэх мэтээр цааш нь ярьж болно. Иргэдийн хэл ярианы соёлыг сайжруулах үүднээс олон хэлний толь болон монгол хэлний тайлбар тольд үгсийг оруулахдаа амьдрал ахуйн чухам ямар салбарт хэрэглэдэгийг заавал тусган өгч байх хэрэгтэй байна.”<sup>37</sup> хэмээн монгол хэлний үг хэллэгийн нийгмийн хэрэглээний практик ач холбогдлын чухал болохыг дурджээ.

Ийнхүү дээрх баримтуудаас үзвэл монгол хэлний бага нэгжээс их нэгж хүртэл ойролцоо утгын бүхэл бүтэн тогтолцоо байж болох бөгөөд энэхүү ойролцоо утгыг харьцааг хэлний бусад нэгжүүдтэй харьцуулан авч үзэх юм бол хэлний бүх нэгж байж болдогоороо бусдаас ялгарах нэг онцлогтой судлагдахуун гэдэг нь харагдаж байна. Ийм учраас ойролцоо утгат харьцааны асуудал бол хэлний бүх тогтолцоонд цогцоор нь авч үзэх ёстой онол, практикийн маш өргөн тархсан, чухал ойлголт байна гэдэг нь мөн харагдаж байна.

## НОМЗҮЙ

### Монгол хэлээр:

Базаррагчаа.М1996, “Ажнай”, Уб.,

Базаррагчаа.М, 2000, “Монгол хэл”, Уб.,

Базаррагчаа.М, 2002, “Утгын чуулган”, Уб.,

Базаррагчаа.М, 2005, “Монгол хэлний өгүүлбэр судлал”, Уб.,

Бат-Ирээдүй.Ж, 1998, “Монгол хэлний ойролцоо утгат үг, хэллэгийн бүтэц, утга үүргийн судалгаа”, Ph.D зэрэг горилсон бүтээл, Уб.,

Бат-Ирээдүй.Ж, 2006, “Монгол хэлний ойролцоо, эсрэг утгат үг хэллэгийн толь бичиг”, Уб.,

Бат-Ирээдүй.Ж нар, 2007, “Монгол хэлний ойролцоо, эсрэг утгат хэлц үгийн сан”, Уб.,

Бат-Ирээдүй.Ж., 2009, “Монгол хэлний хэлзүйн дагавар, нөхцөл, баймж үгийн сан”, Уб.,

Бат-Ирээдүй.Ж, 2010, “Монгол хэлзүйн сан”, Уб.,

Бямбадорж.Б, 2011, “Орчин цагийн монгол хэлний хэлбэр судлал”, Уб.,

Бямбасан.П, 2006, “Монгол хэлний онол, бүтцийн асуудалд”, Уб.,

Головин.Б.Н., 2012, “Хэл шинжлэлийн удиртгал”, Уб.,

Гэрэлмаа. Г., 2012, “Хэрэглээний хэл шинжлэл”, Уб.,

Жамбалсүрэн.Г., 1987, “Монгол хэлшинжлэлийн онолын зарим асуудал”, Уб.,

Идэрбаяр.Б, 2005, “Монгол хэлний төсөөт үг”, Уб.,

Китамура. А, 2001, “Орчин цагийн монгол хэлний ойролцоо утгат үгийн толь бичиг”, Уб.,

Лувсанвандан.С нар, 1966 “Монгол хэлний ойролцоо үгийн товч толь”, Уб.,

Лувсанвандан.Ш, 1981, “Монгол хэлшинжлэлийн асуудлууд”, Уб.,

Лувсанвандан.Ш, 2010, “Хэлшинжлэлийн онолын асуудлууд”, IX боть, Уб.,

Лувсанжав.Чой, 1964, “Нэр томьёо” (Хэлшинжлэл), ШУА, Уб.,

37. Б.Магсаржав, 2011, “Даяаршлын үеийн монгол хэл бичиг”, Уб., 12 дах тал

Ж.Баг-Ирээдүй

- Б.Магсаржав, 2011, “Даяаршлын эриний монгол хэлбичиг”, Уб.,  
Мөнгөнцэцэг.Б, 2012, “Монгол хэлний ойролцоо зэргэд”, Уб.,  
Мөнх-Амгалан.Б, 1998, “Орчин цагийн монгол хэлний баймжийн ай”, Уб.,  
Нансалмаа.Н, 2005, “Үгийн сан судлал”, Уб.,  
Нансалмаа.Н, 2011, “Үг: утга, хэрэглээ”, Уб.,  
Одонтөр.Ш нар, 1995, “Хэл шинжлэлийн нэр томьёоны зүйлчилсэн тайлбар толь”. Уб.,  
Отгонсүрэн.Д, 1998, “Монгол хэлний үгийн сангийн найруулга зүй”. Уб.,  
Өнөрбаян.Ц, 2004, “Орчин цагийн монгол хэлний үг зүй”. Уб.,  
Пүрэвжав.Э, 1996, “Монгол хэлний хэм хэмжээ”. Уб., ШУА  
Пүрэвжанцан.А нар, 2012, “Монгол хэлний ойролцоо үгийн товч толь” Уб.,  
Пүрэв-Очир.Б, 1998, “Монгол хэлний өгүүлбэрзүй 2”, Уб.,  
Пүрэв-Очир.Б, 2001, “Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй 1”. Уб.,  
Самбуудорж.О, 2011, “Хэлний соёлын тулгамдсан асуудал”, №4. Уб.,  
Саруул-Эрдэнэ.М, 2002, “Монгол хэлний нөхцөл бүтээврийн үгзүйн түүхэн хувьсал” (Аяндаа цэгцрэх тогтолцооны онол болон эволюцийн сургаалаар). Уб.,  
Сүхбаатар.Ц, 2003, “Монгол хэлний найруулгазүйн нэр томьёоны тайлбар толь”. Уб.,  
Сүхбаатар.Ц, 2009, “Монгол хэлний найруулгазүй”, Уб.,  
Сүхбат.Г, 2007, “Найруулах эрдэм хэл ярианы соёл”. Уб.,  
Шагдарсүрэн.Ц, 2010, “Эх хэлээ эвдэхгүй юм сан”, Уб.,  
Энхжаргал.С, 2007, “Монгол хэлний ойролцоо утгат үйл үгийн тухай”, Уб.,  
Шинэбаяр.О, 2012, “Монгол хэлний хэрэглээ, найруулга, уран сайхны эхийн шинжлэл”, Уб.,  
Янжиндулам.В нар, 2012, “Ойролцоо хэлцийн толь”, Уб.,

Англи хэлээр:

- Bat-Ireedui.J., 1998, “The Structure, Meaning and Function of Mongolian Synonyms (words and phrases)”  
Juha A. Janhunen. 2012, “Mongolian” John Benjamins Publishing Company.

Орос хэлээр:

- Бат-Ирээдүй.Ж, 2004, “Система синонимов в современном монгольском языке”. Москва.  
Хэлшинжлэлийн Ухааны доктор (Sc.Dr) хамгаалсан диссертаци.  
“Синонимы русского языка и их особенности”. 1972. Ленинград.